



**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС
МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ
ТӨСВИЙН ТӨЛӨӨЛЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ**

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ**

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь Монгол Улсын хувьд нэн чухал зорилт бөгөөд нэг талаас богино, дунд хугацаанд төсвийн алдагдал үүсэх, гадаад өр нэмэгдэх, эдийн засгийн хямрал үүсэхээс урьдчилан сэргийлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, нөгөө талаас дунд болон урт хугацаанд эдийн засгийн төрөлжилтийг хангах, цаашид эдийн засгийг тогтвортой өсгөх суурь болох ач холбогдолтой юм. Энэ талаар 2024 оны 1 дүгээр сард Дэлхийн Банкнаас боловсруулан гаргасан “Монгол Улсын гадаад худалдааны өрсөлдөх чадварын дүн шинжилгээ” сэдэвт тайланд тодорхой дурдсан байна (Дэлхийн банк “Монгол Улсын гадаад худалдааны өрсөлдөх чадварын дүн шинжилгээ” тайлан, 15-р тал).

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (ТТБТХ)-ийг 2010 онд батлан төсвийн тусгай шаардлага, төсвийн дүрмийг мөрдүүлж ирсэн билээ. ТТБТХ-д зааснаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ) нь тухайн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг гэж үздэг. ДХТХМ нь төсвийн бодлогын гол баримт бичиг болохын хувьд богино хугацааны буюу нэг жилийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтөөс ялгаатай бөгөөд макро эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангахад түлхүү чиглэдэг.

ТТБТХ-ийн 16^{1.1}-д заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-өөс Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн төсөлд шинжилгээг хийж, холбогдох дүгнэлтийг өгч байна.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ДХТХМ-ийн төсөл нь ТТБЗ-өөс 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал”-ын тайланд тусгагдсан эдийн засгийн таамаглал, гадаад дотоод эдийн засгийн эрсдэл, төсвийн үзүүлэлттэй зарим талаар нийцтэй бус байна.

Нэг. Эдийн засаг, гадаад орчны нөхцөл байдалд нийцтэй эсэх

Эдийн засгийн өсөлтийн төсөөллийн хувьд: Өнгөрсөн жилүүдэд макро эдийн засгийн өсөлт болон төсвийн орлогын талаар хэт өөдрөг төсөөлөл боловсруулж, үүндээ тулгуурлан жилийн төсвийг баталж ирсний улмаас төсвийн зарлага хурдтай нэмэгдсэн. Жишээлбэл, 2024 оны байдлаар улсын төсвийн нийт зарлага ДНБ-ий 37 хувьтай тэнцэхээр байгаа нь хөгжиж буй бүхий л улс орны үзүүлэлтээс даруй 10 гаруй нэгжээр өндөр байгаа юм.

Цар тахлын дараагийн жилээс нүүрсний экспортын орлогыг дагаж төсвийн зарлага ихээхэн өссөн нь цаашид эдийн засагт дарамт учруулах хэмжээнд хүрч болзошгүй байна. Учир нь манай улсын экспортын орлого нэг түүхий эд, нэг улсаас өндөр хамааралтай учраас гадаад хүчин зүйлийн нөлөөнд тун эмзэг юм.

Иймд цаашид тулгарч болзошгүй түүхий эдийн үнийн уналт, экспортын орлогын тасалдал, төсвийн алдагдал нэмэгдэх эрсдэлээс урьдчилан сэргийлж төсвийн орлого, зарлагын өсөлтийг зайлшгүй сааруулах шаардлагатай гэж үзэж байна.

Далайд гарцгүй, түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлтийн мөчлөг харьцангуй богино байгааг Монголбанкны судлаачдын

боловсруулсан “Монгол Улсын эдийн засгийн мөчлөгийн талаарх судалгаа”-нд дурдсан (Д.Ган-Очир, Б.Мөнхбаяр, 2017) байдаг.

ОУВС, Дэлхийн банкны судлаачид болон ажлын хэсгийн гаргасан тайлан, зөвлөмжид “төсвийн зарлагын хэт өсөлтөөс татгалзах, түүхий эдийн үнийн өсөлтөөс бий болж буй нэмэгдэл орлогыг урсгал төсөвт зарцуулахгүй байх, уг орлогыг тогтворжуулалтын болон хуримтлалын санд түлхүү хуваарилж, цаашид тулгарч болзошгүй эдийн засгийн хүндрэл, хямралаас сэргийлж байх”-ыг байнга зөвлөмж болгож ирсэн билээ (IMF Staff Concluding Statement of the 2022 Article IV Mission Mongolia). (Хавсралт 1)

Нүүрсний экспортын биет хэмжээ, экспортын орлогын төсөөллийн хувьд: Австрали улсын нүүрсний экспорт 2025-2026 онд 15.0 сая тонноор нэмэгдэх, ОХУ-ын Саха улсын Эльга нүүрсний уурхайгаас Номхон далайн боомт тийш барьж буй шинэ төмөр зам, далайн боомт ашиглалтад орсноор 2025 онд тус уурхайгаас экспортод гаргах боломжтой нүүрсний хэмжээ 15.0-20.0 сая тонноор нэмэгдэх нөхцөл бүрдэж байна. БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл ирэх 2025-2026 онд өсөх төлөвгүй байна гэж Австрали улсын Аж үйлдвэр, шинжлэх ухаан, эрдэс баялгийн яамнаас гаргасан тоймд өгүүлжээ (Department of Industry, Science and Resources).

Өнгөрсөн 2023 онд Хятад улс гадаад улс орнуудаас нийтдээ 103,0 сая коксжих нүүрсийг импортоор авсан. Энэхүү импортын хэмжээ өсөх эсэх нь Хятад улсын эдийн засгийн нөхцөл байдал, гангийн үйлдвэрлэл, экспортын хандлагаас ихээхэн хамаарна гэдгийг бид онцгой анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн гадаад зах зээлд үзүүлэх геополитикийн нөлөө ээдрээтэй, тодорхойгүй, түүхий эдийн гол худалдан авагч БНХАУ-ын эдийн засагт тулгамдаж буй асуудлууд ихтэй (ирэх 7 дугаар сард Хятадын Коммунист Намын Төв хороо эдийн засгийн хөгжлийн асуудлаар тусгайлан хуралдахаар товлосон), ОХУ-ын зүгээс БНХАУ-д экспортлох газрын тос, шатдаг хий, нүүрсний хэмжээг ихээхэн нэмэгдүүлсээр байгаа ийм цаг үед ирэх 2025 оны эдийн засгийн өсөлт, экспортын орлогыг хэт өөдрөгөөр төсөөлөх нь ихээхэн эрсдэл дагуулж болзошгүй байна.

Манай улсын тухайд Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын үргэлжлэл, төмөр замын Гашуунсухайт өртөөнөөс Ганц модны боомт хүртэл гүүрэн зам бүхий төмөр замыг барьж байгуулах ажил 2024-2025 онд үргэлжилж, 2025 оны намар ашиглалтад орох боломжтой байгаа тул ирэх оны нүүрсний экспортод үзүүлэх нөлөө харьцангуй бага байх төлөвтэй байна.

Иймээс Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн ДХТХМ-ийн төсөлд тусгагдсан нүүрсний экспортын орлого, улмаар төсвийн нийт орлого нь бодит байдлаас *ихээхэн өндөр, хэт өөдрөг төлөвлөгдсөн байна* гэж үзэж байна.

Харин бодит байдлаа харвал экспортын болон төсвийн гүйцэтгэл төсөөлж буй хэмжээнээс буурах, төсвийн орлого тасалдах, улмаар улсын төсвийн алдагдал нэмэгдэх, 2025 оны төсвийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч орлого, санхүүжилтийн тасалдлын улмаас хэрэгжиж буй хөрөнгө оруулалт зогсох, он дамжих хөрөнгө оруулалт, барилга объектын тоо нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэхээр байна.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам”-ын талаар хийсэн судалгааг Эдийн засгийн шинжилгээ, судалгааны төвийн судлаачид саяхан олон нийтэд танилцуулсан нь төсвийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, тайлагналтад анхаарах ёстой чухал зөвлөмжүүдийг багтаажээ.

Өргөн мэдүүлсэн Төсвийн Хүрээний мэдэгдлийн иж бүрдэл хангагдсан эсэх тухайд:

ТТБТХ-ийн 12.3.3-д заасан “макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ”-г Төсвийн хүрээний мэдэгдлийн багц баримт бичигт тусгах шаардлагатай.

Мөн хуулийн 12.3.4-т заасан “өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон ДНБ, хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт, ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшин, төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны урсгал тэнцлийн талаарх макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд”, 12.3.8-д заасан “өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл, төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт, төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл, улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалтын талаарх нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд” зэрэг зохицуулалтын агуулга өргөн мэдүүлсэн төслийн багцад бүрэн тусгагдаагүй байна.

Хоёр. Макро эдийн засгийн болон нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, таамаглалын нийцэл, төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх

ТТБЗ-өөс Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулахдаа дараах үндсэн зарчмуудыг баримталж эдийн засгийн өсөлт, нэгдсэн төсвийн гол үзүүлэлтүүдийг тооцоолон Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Үүнд:

- Монгол Улсын төсвийн бодлого нь мөчлөг сөрсөн, макро эдийн засгийн зорилго, тогтвортой өсөлтийг дэмжсэн байх;
- Төсвийн тэлэлтийг багасган төсвийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлийг бууруулах;
- Төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын оновчтой байдлыг хангах, ДНБ-д эзлэх нийгмийн халамжийн зардлын хувь хэмжээг багасгах замаар төсвийн зарлагын бодлогыг сайжруулах;
- Төсвийн орлого нэмэгдэж байгаа таатай нөхцөлд цалин, тэтгэвэр тэтгэмжээс бусад төсвийн урсгал зардлыг тодорхой хугацаанд тогтвортой хадгалах гэх мэт.

Хэдийгээр ТТБЗ-ийн тооцооллын үр дүнд ДНБ-ийн өсөлт өндөр байх боломжтой гарсан ч макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн тухайд харгалзан үзвэл зохих дээд, доод хувилбар буюу хязгаарыг санал болгосон. Ингэхдээ бодлогын үндсэн зорилтыг ДНБ-д төсвийн орлого, зарлагын эзлэх хувь хэмээн үзэж илүү гарсан орлогыг хуримтлуульж, эдийн засгийн хөгжлийг дэмжих, төсвийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулах нь зүйтэй гэж тооцсон.

Гэтэл Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн төсөл нь ТТБЗ-ийн зүгээс санал болгосон бодлого, макро эдийн засаг, төсвийн гол үзүүлэлтүүдийн таамаглалтай зарим талаар нийцэж байгаа боловч төсвийн бодлогын үндсэн хэсэг болох төсвийн орлого, зарлагын өсөлт, ДНБ-д төсвийн орлого, зарлагын эзлэх хувь зэрэг үзүүлэлтийн хувьд зөрүүтэй байна. Тухайлбал:

- ДНБ-ийн өсөлт, түүнийг дагаад төсвийн орлогыг хэт өөдрөг төсөөлсөн нь төсвийн тэлэлт үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлж байна. ДНБ-ийн өсөлтийг 2024 онд 6 хувь, 2025 онд 8 хувь, нүүрсний экспортыг 2024 онд 78 сая тонн, цаашид илүү нэмэгдэхээр таамагласан нь биелэх боломж тааруу, эрсдэлийг өдөөсөн хувилбар болсон байна.
- Төсвийн орлого ирэх гурван жилд ТТБЗ-өөс санал болгосон өөдрөг төсөөллөөс 10.1 их наяд, эрсдэлийг бууруулах чиглэлд хийсэн төсөөллөөс 15.6 их наяд төгрөгөөр

нэмэгдэж, төсвийн зарлага харгалзан 7.4 их наяд болон 13.3 их наяд төгрөгөөр өндөр төлөвлөгджээ.

- ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувийг дунд хугацаанд бууруулахаар тооцсон боловч бий болсон бодит боломжийг бүрэн ашиглахаар тусгаагүй, ТТБЗ-ийн санал болгосон түвшнээс 4.8-5.4 хувиар өндөр байна. Энэ нь эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах нөхцөлийг хангалттай бүрдүүлж чадахгүйгээс гадна өөдрөг төсөөлөл биелээгүй тохиолдолд бодит байдалд төрийн оролцооны түвшин үүнээс ч өндөр байх боломжтой харагдаж байна.
- Нэгдсэн төсвийн зарлагыг 2025 онд 14.4 хувь, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 3.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий 4.1 хувьтай тэнцэх хэмжээгээр өсгөж, 31.3 их наяд болгохоор тооцсон нь цар тахлын дараах төсвийн тэлэлтийг үргэлжлүүлж, 2022 оноос хойш 1.7 дахин буюу 13.1 их наяд төгрөгөөр, 2019 онтой харьцуулахад 2.6 дахин өсөх нөхцөлийг бүрдүүлж байгаа нь төсвийн тэлэлтийн хурд эрчимтэй нэмэгдэж байгааг илтгэж байна.
- ДНБ-д эзлэх өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн нийт хэмжээг төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн танилцуулгад 2024 онд 39.6 хувь, 2025 онд 37.3 хувь, 2026 онд 38.8 хувь, 2027 онд 38.3 хувьтай байхаар төсөөлсөн хэдий ч 2025 онд 50 хувь, 2026 онд 45 хувь, 2027 онд 40 хувь болгоно гэж тусгасан байна. Энэ нь ТТБТХ-ийн анхны батлагдсан түвшинтэй дүйцэх эерэг өөрчлөлт юм.
- Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2025 онд 2.0 хувь, 2026 онд 1.5 хувь, 2027 онд 1.0 хувь байхаар тооцсон нь хуулийн ерөнхий шаардлагыг хангаж байгаа боловч өөдрөгөөр тооцсон төсвийн орлого тасалдвал төсвийн алдагдал нэмэгдэж, шинэ өр үүсэх нөхцөлийг бүрдүүлэх магадлалтай байна.

Нэгтгэн дүгнэвэл, Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд төсвийн орлого, зарлага ихээхэн нэмэгдэхээр тооцсоноос үзвэл мөчлөг дагасан төсвийн бодлогыг цаашид хэвээр хадгалахаар байна.

Ийнхүү төсвийн тэлэлтийг цаашид хэвээр хадгалах аваас эдийн засгийн хөгжлийг дэмжих, төсвийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах бодлогын зорилт хэрэгжихгүй байх магадлал өндөр байна. Түүнээс гадна өргөн барьсан ДХТХМ-ийн үзэл баримтлалд энэхүү баримт бичгийн нийгэм, эдийн засгийн үр дагаврыг зөвхөн төсөв боловсруулах тооцоолол хийх гэж өнгөцхөн тодорхойлжээ.

Үүнээс гадна 1) Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн таамаглал өндөр байгаа нь хэт өөдрөг төсөөлөлд суурилсан, 2) Төсвийн хувьд өмнөх алдаа буюу төсвийн хэт тэлэлт, мөчлөг дагасан, эрсдэлийг нэмэгдүүлэх бодлого хэвээр хадгалагдсан, 3) Төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд өмнөх зохисгүй бодлого үргэлжлэх хандлагатай байна.

Өргөн барьсан төсөлд инфляцыг гурван хувьд хүргэх, өрийн хэмжээ, ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулах, төсвийн алдагдлыг хуулийн хязгаарт барих, улмаар бууруулах, гол үзүүлэлтүүдийг сайжруулах зорилт дэвшүүлсэн нь сайшаалтай боловч эдгээр таамаглал нь зөвхөн гадаад худалдаа, эдийн засгийн ихээхэн өөдрөг төсөөлөл биелэгдэх нөхцөлд хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Зөвлөмж:

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 төсөөлөл нь эдийн засгийн хөгжил, төсвийн тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах шаардлагад нийцсэн байх ёстой гэдэг үүднээс Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Эдийн засгийн гадаад дотоод эрсдэл, бодит нөхцөл байдлыг Дунд Хугацааны Төсвийн Хүрээний мэдэгдэлд харгалзан үзэх, төсвийн орлого нэмэгдэж байгаа үед хуримтлал үүсгэх, эрсдэлийг бууруулах бодлого баримтлах;
- Төсвийн орлогын өөдрөг төсөөлөлд найдаж төсвийг тэлэх бодлогыг цаашид үргэлжлүүлэхээр байгааг эргэж харах;
- Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, орлого өндөр байгаа жилүүдэд хуримтлал үүсгэх, мөчлөг сөрсөн бодлого баримтлах шаардлагыг төсөлд харгалзан үзээгүй байгааг анхаарч ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувийг өнөөгийн түвшнээс бууруулж 28-иас доош хувьд хүргэх;
- Зөвхөн эрдэс түүхий эдийн экспортод дулдуйдсан бодлого хэрэгжүүлэх нь эдийн засгийн төрөлжилт бий болох нөхцөлийг хязгаарлаж байгаа төдийгүй эдийн засагт учрах эрсдэлийг нэмэгдүүлж байгааг анхааран үзэх;
- Төсвийн тусгай шаардлагыг хангахаас гадна Төсвийн Тогтвортой Байдлын тухай хуульд заасан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн агуулгыг бүрэн тусгаж, хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

WORLDBANK: MONGOLIA TRADE COMPETITIVENESS DIAGNOSTIC

Эдийн Засгийн Мөчлөгийн эсрэг бодлого явуулах нь арилжааны салбарыг хөгжүүлэх илүү тогтвортой орчинг бүрдүүлнэ. Төсвийн бодлого нь одоогийн бүрдээд буй тогтворжуулалт, хуримтлалын санг ашиглан урт хугацааны тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ төсвийн тогтворжилтыг дэмжихэд чиглэгдэх ёстой.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Монголбанкны бие даасан байдлыг бэхжүүлэх, институтийн шинэчлэл хийх замаар үүнийг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Мөнгөний бодлого нь инфляцыг тогтоон барих, гадаад тэнцвэргүй байдлыг арилгахад чиглэгдсэн байх, макро эдийн засгийн бодлогын удирдлага нь валютын ханшийн уян хатан байдлыг хангах ёстой.

Эх сурвалж: Дэлхийн Банкнаас 2024 оны 1-р сард боловсруулан гаргасан “Монгол Улсын Гадаад Худалдааны Өрсөлдөх чадварын дүн шинжилгээ” тайлангаас.

IMF Report: MONGOLIA Public Investment Management Assessment Update:

Хялбаршуулсан төсвийн дүрмийн тогтолцоог баталж, төсвийн хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар төсвийн хариуцлагыг бэхжүүлэх хэрэгтэй.

Үүний үр дүнд улсын өрийн хамрах хүрээг өргөжүүлэх, урьдчилан сэргийлэх, залруулах арга хэмжээг боловсруулах, төсвийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавихад зэрэг чиглэлээр **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн** гүйцэтгэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой болно.

Эх сурвалж: ОУВС-гаас 2024 оны 4-р сард боловсруулан гаргасан “Монгол улс: Улсын Хөрөнгө Оруулалтын Удирдлагын талаарх шинэчилсэн үнэлгээний тайлан”-нд тусгагдсан дүгнэлтээс.

----- о О о -----